



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН 2021 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН  
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/05/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Г.Гүнжидмаа  
Утас: 261628 Цахим хаяг: [gunjidmaag@audit.gov.mn](mailto:gunjidmaag@audit.gov.mn)  
Аудитор: Г.Мөнхчимэг  
Утас: 260512 Цахим хаяг: [munkhchimegg@aaudit.gov.mn](mailto:munkhchimegg@aaudit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Мөнгөн оршдос Аудит ХХК  
Захирал: Ц.Таванчулуу  
Утас: 99177464 Цахим хаяг: [tavanchuluu.ts@moaudit.com](mailto:tavanchuluu.ts@moaudit.com)

Улаанбаатар хот  
2022 он

## **Агуулга**

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	0

### **Товчилсон үгийн жагсаалт**

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлгэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ  
ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН ДАРГА  
Т.ТҮДЭВДАГВА ТАНАА

2022.02.25 № 07/365  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>335,652,322.26</b>	<b>196,767,597.96</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	0.00	0.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>637,206.00</b>	<b>0.00</b>
<b>33300</b>	<b>Татаас санхүүжилтийн авлага</b>	637,206.00	0.00
335	Бусад авлага	0.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>335,015,116.26</b>	<b>196,767,597.96</b>
351	Түүхий эд материал	42,903,389.25	13,602,880.96
35110	Тусгай зориулалттай материал	7,813,336.25	
35130	Эм боох материал	35,090,053.00	13,602,880.96
354	Хангамжийн материал	292,111,727.01	183,164,717.00
35410	Бичиг хэргийн материал	2,708,050.00	336,000.00
35420	Аж ахуйн материал	36,107,572.00	32,780,681.00
35430	Сэлбэг хэрэгсэл	239,869,808.78	145,875,075.00
35440	Түлш, шатах тослох материал	0.00	1,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	13,426,296.23	3,172,961.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,194,684,688.55</b>	<b>3,956,251,109.52</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	00.00	00.00
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,194,684,688.55</b>	<b>3,956,251,109.52</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>3,037,016,159.15</b>	<b>3,798,093,358.40</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	797,854,191.00	797,854,191.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,206,358.68)	(74,363,220.52)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	22,700,000.00	22,700,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(22,700,000.00)	(22,700,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,472,312,810.41	4,103,236,630.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,198,666,654.76)	(1,076,367,327.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,326,266.00	62,979,875.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(30,604,094.82)	(15,246,790.41)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>157,668,529.40</b>	<b>158,157,751.12</b>
39301	Программ хангамж	1,731,336.00	1,731,336.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,559,446.60)	(1,070,224.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	157,496,640.00	157,496,640.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,530,337,010.81</b>	<b>4,153,018,707.48</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>637,206.00</b>	<b>0.00</b>
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	637,206.00	0.00
4132	Бараа үйлчилгээний зардлыг өглөг	0.00	0.00
4136	Бусад өглөг	0.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,529,699,804.81</b>	<b>4,153,018,707.48</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,529,699,804.81	4,153,018,707.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	3,760,586,825.51	3,760,586,825.51
51101	Өмч: - төрийн	3,760,586,825.51	3,760,586,825.51
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(539,611,203.20)	83,707,699.47
51210	Өмнөх үеийн үр дүн	(539,611,203.20)	(539,611,203.20)
51220	Тайлант үеийн үр дүн		623,318,902.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	308,724,182.50	308,724,182.50
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,530,337,010.81</b>	<b>4,153,018,707.48</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,499,288,659.76</b>	<b>2,066,140,251.86</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,826,374,022.76</b>	<b>1,421,163,265.86</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,826,374,022.76	1,421,163,265.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,826,374,022.76	1,421,163,265.86
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,737,506.00	49,140,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,790,636,516.76	1,372,022,365.86
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>672,914,637.00</b>	<b>644,976,986.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	610,873,000.00	577,271,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	610,873,000.00	577,271,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	59,607,978.00	63,088,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	403,200.00	722,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	59,204,778.00	62,365,200.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,433,659.00</b>	<b>4,617,086.00</b>
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>870,449,805.68</b>	<b>1,442,821,349.19</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>870,449,805.68</b>	<b>1,442,821,349.19</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	804,765,765.68	1,397,789,844.32
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	401,557,980.00	390,782,785.35
210101	Үндсэн цалин	271,486,424.00	245,906,015.53
210102	Нэмэгдэл	104,247,203.56	111,615,369.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,824,52.44	33,261,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,876,500.00	52,876,600.00
210201	Тэтгэврийн даатгал	37,209,400.00	37,209,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,916,700.00	3,916,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,133,500.00	3,198,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	783,300.00	718,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,833,600.00	7,833,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	31,404,161.00	36,987,068.00
210301	Гэрэл, цахилгаан	21,860,530.00	24,678,786.00
210302	Түлш, халаалт	7,840,471.00	10,258,764.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,703,160.00	2,049,518.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,948,985.00	19,651,604.50
210401	Бичиг хэрэг	848,500.0	4,875,930.00
210402	Тээвэр, шатахуун	5,051,000.00	2,927,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,692,929.00	2,226,754.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	320,000.00	305,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,036,556.00	9,316,920.50
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	37,132,819.00	90,136,970.13
210501	Эм	33,688,319.00	70,788,596.13
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,444,500.00	19,348,374.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	9,098,357.00	174,547,990.81
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,556,799.00	170,592,892.81
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,387,940.00	3,955,892.81
210604	Урсгал засвар	2,153,618.00	
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,123,640.00	2,354,880.00
210702	Дотоод албан томилолт	3,123,640.00	2,354,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	20,409,938.00	11,160,590.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,680,150.00	5,529,4330.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,689,280.00	2,654,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	186,980.00	184,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,380.00	125,908.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	
210807	Газрын төлбөр	2,668,148.00	2,667,152.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>237,213,385.68</b>	<b>619,291,355.53</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,315,100.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,956.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	234,893,329.68	619,291,355.53
<b>27</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>65,684,040.00</b>	<b>45,031,504.87</b>
	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>55,313,727.00</b>	<b>19,579,586.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,433,659.00	4,617,086.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	14,962,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,580,068.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	3,000,000.00	
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,370,313.00	25,451,918.87
КТ(213303)	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,370,313.00	25,451,918.87
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)</b>	<b><u>1,628,838,854.08</u></b>	<b><u>623,318,902.67</u></b>
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)</b>		
КТ(225001)	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV-V)</b>		
	<b>НИЙТ ҮР ДҮН (VII)=(III)+(VI)</b>	<b><u>1,628,838,854.08</u></b>	<b><u>623,318,902.06</u></b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,760,586,825.81</b>	<b>308,724,182.50</b>	<b>(2,168,450,057.28)</b>	<b>1,900,860,950.73</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>				
Тайлант үеийн үр дүн			1,628,838,854.08	1,628,838,854.08
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,760,586,825.51</b>	<b>308,724,182.50</b>	<b>(539,611,203.20)</b>	<b>3,529,699,804.81</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	3,760,586,825.51	308,724,182.50	(539,611,203.20)	3,529,699,804.81
Тайлант үеийн үр дүн			623,318,902.67	623,318,902.67
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,760,586,825.51</b>	<b>308,724,182.50</b>	<b>83,707,699.47</b>	<b>4,153,018,707.48</b>



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>708,652,143.00</b>	<b>694,117,886.00</b>
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,737,506.00	49,140,900.00
	Нийтлэг татварын бус орлого	35,737,506.00	49,140,900.00
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	35,737,506.00	49,140,900.00
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,737,506.00	49,140,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>672,914,637.00</b>	<b>644,976,986.00</b>
	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>610,873,000.00</b>	<b>577,271,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	610,873,000.00	577,271,900.00
	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>59,607,978.00</b>	<b>63,088,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	403,200.00	722,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	59,204,778.00	62,365,200.00
	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,433,659.00</b>	<b>4,617,086.00</b>
	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	2,433,659.00	4,617,086.00
	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>701,575,853.00</b>	<b>675,022,286.00</b>
	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>701,575,853.00</b>	<b>675,022,286.00</b>
	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>635,891,813.00</b>	<b>629,990,781.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>401,557,980.00</b>	<b>390,782,785.35</b>
210101	Үндсэн цалин	271,486,424.00	245,906,015.53
210102	Нэмэгдэл	104,247,203.56	111,615,369.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,824,352.44	33,261,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,876,500.00</b>	<b>52,876,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	37,209,400.00	37,209,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,916,700.00	3,916,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,133,500.00	3,133,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	783,300.00	783,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,833,600.00	7,833,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>31,404,161.00</b>	<b>36,987,068.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	21,860,530.00	24,678,786.00
210302	Түлш, халаалт	7,840,471.00	10,258,764.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,703,160.00	2,049,518.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,116,551.00</b>	<b>17,062,316.00</b>
210401	Бичиг хэрэг	1,706,500.00	2,723,400.00
210402	Тээвэр, шатахуун	5,051,000.00	3,927,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,692,929.00	2,226,754.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэчдийн устгал, ариутгал	320,000.00	305,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,346,122.00	7,880,162.00
<b>22010310</b>	<b>Норматив зардал</b>	<b>46,304,200.00</b>	<b>52,467,474.00</b>
210501	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	40,395,200.00	35,191,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,909,000.00	17,275,874.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>60,783,743.00</b>	<b>66,299,067.78</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,023,403.00	64,134,067.78
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,777,340.00	1,372,000.00
210604	Урсгал засвар	5,983,000.00	793,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,123,640.00</b>	<b>2,354,880.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,123,640.00	2,354,880.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>20,409,938.00</b>	<b>11,160,590.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,680,150.00	5,529,430.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,689,280.00	2,654,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	186,980.00	184,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	130,380.00	125,908.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	
210807	Газрын төлбөр	2,668,148.00	2,667,152.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,315,100.00</b>	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,315,100.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>65,684,040.00</b>	<b>45,031,504.87</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>55,313,727.00</b>	<b>19,579,586.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	2,433,659.00	4,617,086.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	300,000.00	14,962,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,580,068.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	3,000,000.00	
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,370,313.00</b>	<b>25,451,918.87</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,370,313.00	25,451,918.87
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>7,076,290.00</b>	<b>19,095,600.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>7,076,290.00</b>	<b>19,095,600.00</b>
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,076,290.00</b>	<b>19,095,600.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>7,076,290.00</b>	<b>19,095,600.00</b>
2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	7,076,290.00	19,095,600.00
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(7,076,290.00)</b>	<b>(19,095,600.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	601,971,900.00	600,969,167.13	1,002,732.87	99.8
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	601,971,900.00	600,969,167.13	1,002,732.87	99.8
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	601,971,900.00	600,969,167.13	1,002,732.87	99.8
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	391,677,900.00	390,782,785.35	895,114.65	99.8
Үндсэн цалин	245,990,000.00	245,906,015.53	83,84.47	100.0
Нэмэгдэл	112,424,800.00	111,615,369.82	809,430.18	99.3
Унаа хоолны хөнгөлөлт	33,263,100.00	33,261,400.00	1,700.00	100.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,876,600.00	52,876,600.00		100.0
Тэтгэврийн даатгал	37,209,400.00	37,209,400.00		100.0
Тэтгэмжийн даатгал	3,916,800.00	3,916,800.00		100.0
ҮОМШӨ-ний даатгал	3,133,400.00	3,133,400.00		100.0
Ажилгүйдлийн даатгал	783,400.00	783,400.00		100.0
Эрүүл мэндийн даатгал	783,600.00	783,600.00		100.0
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,666,500.00	32,640,890.00	25,610.00	99.9
Гэрэл, цахилгаан	21,029,800.00	21,029,273.00	527.00	100.0
Түлш, халаалт	9,562,900.00	9,562,099.00	801.00	100.0
Цэвэр, бохир ус	2,073,800.00	2,049,518.00	24,282.00	98.8
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10,627,300.00	10,626,154.00	1,146.00	100.0
Бичиг хэрэг	2,723,400.00	2,723,400.00		100.0
Тээвэр, шатахуун	2,927,200.00	2,927,000.00	200.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,676,900.00	1,676,754.00	146.00	99.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,994,100.00	2,994,000.00	100	100.0
<b>Норматив зардал</b>	<b>35,327,400.00</b>	<b>35,325,000.00</b>	<b>2,400.00</b>	<b>100.0</b>
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,400,000.00	33,400,000.00		100.0
Нормын хувцас зөөлөн эдлэл	1,927,400.00	1,925,000.00	2,400.00	99.9
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	65,499,800.00	65,495,067.78	4,732.22	100.0
Багаж, техник, хэрэгсэл	63,333,100.00	63,330,067.78	3,032.22	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,372,800.00	1,372,000.00	800.00	99.9
Урсгал засвар	793,900.00	793,000.00	900.00	99.9
<b>Томилолт, зочны зардал</b>	2,184,000.00	2,182,080.00	1,920.00	99.9
Дотоод албан томилолт	2,184,000.00	2,182,080.00	1,920.00	99.9
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	11,112,400.00	11,040,590.00	71,810.00	99.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,466,500.00	5,409,430.00	57,070.00	99.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,654,000.00	2,654,000.00		100.0
Даатгалын үйлчилгээ	187,000.00	184,100.00	2,900.00	98.4
Тээврийн хэрэгслийн татвар	130,900.00	125,908.00	4,992.00	96.2

Газрын төлбөр	2,674,000.00	2,667,152.00	6,848.00	99,7
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>				
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>				
<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>				
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	601,971,900.00	600,969,167.13	1,002,732.87	99.8
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	24,700,000.00	49,140,900.00	(24,440,900.00)	199.0
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	577,271,900.00	551,828,267.13	25,443,632.87	95.6
Улсын төсвөөс санхүүжих	577,271,900.00	551,828,267.13	25,443,632.87	95.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,700,000.00	49,140,900.00	(24,440,900.00)	199.0
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>				
<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>				
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	36	36		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	28	28		100.0
Үйлчлэх ажилтан	7	7		100.0

### **3. Аудитын тайлан**

---

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Туул голын сав газрын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн асуудалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Мөнгөн оршдос Аудит ХХК-ийн аудитор Б.Тамир, аудиторын туслах Г.Содбилэг нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Б.Отгонцэцэг, захирал Ц.Таванчулуу нар хэрэгжүүлсэн.

Туул голын сав газрын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мөнгөн оршдос Аудит ХХК-нд 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 02/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори нь Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1 дахь заалтын дагуу Байгаль орчны сайдын 2006 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 93 тоот тушаалаар Байгаль орчны шинжилгээний төв лаборатори, Багаж хэмжил зүйн төвийг нэгтгэн Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори болон зохион байгуулагдсан Ус цаг уур орчны хяналт шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, багаж хэмжлийн хэрэгслийг төрийн нэрийн өмнөөс баталгаажуулах, байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг улсын хэмжээнд хариуцах үүрэг бүхий Төрийн захиргааны байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”

Тус байгууллага Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2020 оны 08 дугаар сарын 25-ны өдөр А/170 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Цаг уур орчны шинжилгээний газрын Захиргаа аудитын хэлтсээс 2021 оны 11 дүгээр сарын 29, 30-ны өдрүүдэд тус байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн дотоод аудит болон технологийн дотоод хяналт шалгалт хийж санхүүгийн үйл ажиллагаанд дүгнэлт, зөвлөмж өгөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн “нийт зардал”-ын 672,914.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,729.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,710.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 622,681.7 мянган төгрөгөөр буюу 17.7 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	637.2	-	(637.2)
Бараа материал	335,015.1	196,767.6	(138,247.5)
Үндсэн хөрөнгө	3,194,684.7	3,956,251.1	761,566.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,530,337.0</b>	<b>4,153,018.7</b>	<b>622,681.7</b>
Өглөг	637.2	-	(637.2)
Төрийн өмч	3,760,586.8	3,760,586.8	-
Хуримтлагдсан үр дүн	(539,611.2)	83,707.7	(455,903.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	308,724.2	308,724.2	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,530,337.0</b>	<b>4,153,018.7</b>	<b>622,681.7</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлт байна. Үүнд:

- Бараа материалын дансны үлдэгдэл 196,767.6 мянган төгрөг болж 138,247.5 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн үйл ажиллагааны орлого олохтой холбоотой шинжилгээний бодис зарцуулалт нэмэгдсэн нь нөлөөлжээ;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,956,251.1 мянган төгрөг болж 761,566.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 508 тогтоолоор үндсэн хөрөнгийг дахин үнэлсэн нь нөлөөлсөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 577,271.9 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого, агаар, ус, хөрсний шинжилгээний төлбөр, багаж баталгаажуулалтын төлбөр болох өөрийн үйл ажиллагааны орлогоор 24,700.0 мянган төгрөг, нийт 601,971.9 мянган төгрөг урсгал зардалд зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр төсвийн гүйцэтгэлээр 551,828.3 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, өөрийн үйл ажиллагааны орлогоор 49,140.9 мянган төгрөг, нийт 600,969.2 мянган төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд зарцуулсан байна. Гүйцэтгэлээр урсгал зардлыг 1,002.7 мянган төгрөгөөр хэмнэж, улсын төсвөөс авах санхүүжилтийн орлогыг 25,443.6 мянган төгрөгөөр буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөг/*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71408	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент	571,805.4	546,418.8	(25,386.6)	95.5
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	571,805.4	546,418.8	(25,386.6)	95.5
1.2	80219	Харуул хамгаалалтын зардал	5,466.5	5,409.4	57.0	98.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайланд онд 505 ААН-ээс 111,467.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн ба уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Үндсэн үйл ажиллагаанаас орох орлогын тайлант хугацааны төлөвлөгөөнд 24,700.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн боловч төлөвлөгөө 86,767.0 мянган төгрөгөөр давж биелсэн нь цаашид орлогын төлөвлөгөөг өмнөх оны орлогын гүйцэтгэлтэй уялдуулах шаардлагатай харагдаж байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгаль орчин хэмжил зүйн төв лабораторийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу дараах байдлаар нийцлийн аудитын асуудлыг тайланд тусгасан болно.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори нь 2021 онд нийт 601,971.9 мянган төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	-	-	100.0
Төлбөрийн акт	1	44.0	1	44.0	-	-	100.0
Зөвлөмж	1	-	1	-	-	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>44.0</b>	<b>2</b>	<b>44.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>100.0</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.



#### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар алдаа зөрчлийг давтан гаргахгүй талаар 1 зөвлөмж өглөө.

##### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### ***Төслийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ашиглалтгүй хөрөнгөтэй холбоотой асуудал***

***Илрүүлэлт:*** Тайлант онд бараа материалын дансанд 2012 онд Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын баталсан “Орчны хяналт шинжилгээний багаж, тоног төхөөрөмжийн хуваарилалт” жагсаалтаар хүлээн авсан сэлбэг хэрэгслийн нэр төрөл, тоо ширхгээр задалж бүртгээгүй нийт дүнгээр багцалж бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалтыг хэрэгжүүлж үндсэн хөрөнгийг ангиллын дагуу зохих дансанд бүртгэж байх, 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Өгсөн зөвлөмж:*** Бараа материал дансны бүртгэлийг зөв хөтлөх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс					
							Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар</b>												
1	Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори	АХГ-2022/05/НА-СТА-ТШЗ	Бараа материалын дансанд сэлбэг хэрэгслийг нэр төрөл, тоо хэмжээ, нэгж үнээр бүртгээгүй байна.	НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэснийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.	1						1	
<b>ДҮН</b>					<b>1</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>

## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing.



# ТЭМДЭГЛЭЛ

A series of 27 horizontal dotted lines for writing.